

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020 оны 5 дугаар сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Тус газрын 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг санхүүжилтын эх үүсвэр тус бүрээр тоо баримт, биелэлтийн хувь болон зохион байгуулсан худалдан авалтын талаар:

Төсвийн ерөнхийлөн захирагч Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/223 тоот тушаалаар улсын төсвийн хөрөнгө оруулалт, урсгал төсвөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг баталсан.

Уг төлөвлөгөөний дагуу 2020 оны эхний хагас жилийн байдлаар худалдан авах ажиллагаатай холбоотой дараах ажил хийгдсэн. Үүнд:

Нээлттэй тендер шалгаруулалт

2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны 1 сарын 9-ны өдрийн А/61 тоот тушаалаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын албан хэрэгцээнд шаардагдах улсыг мэдээллийн маягт нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий, мөн өдрийн А/62 тоот тушаалаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын албан хэрэгцээнд шаардагдах шатахуун нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий, мөн өдрийн А/67 тоот тушаалаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын албан хэрэгцээнд шаардлагатай багаж, техник хэрэгсэл нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий, А/68 тоот тушаалаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын албан хэрэгцээнд шаардлагдах бичиг хэргийн материал нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороог тус тус байгуулагдаж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.

1.2. Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авах ажиллагааны талаарх тайлбар, үндэслэл болон хэрэгжилтийн талаар:

2020 оны хөрөнгө оруулалтаар баригдах цогцолбор төвийг Сүхбаатар дүүргийн өөрийн эзэмшил газар буюу үйлчилгээний 2,3 дугаар байрын суурин дээр барьж байгуулахаар төлөвлөсөн. Үйлчилгээний 1,2,3 байрны албан хаагчид болон архивын баримт материалыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой ерөнхий газрын даргын 2020 оны 01 сарын 31-ны өдрийн А/132 тоот тушаалаар сүлжээний шилэн кабель татах, архивын тавиур худалдан авахаар үнэлгээний хороог байгуулсан. Үнэлгээний хороо нь Улсын бүртгэлийн ерөнхий архивын тавиур нийлүүлэх барааны УБЕГ/202017, Шилэн кабель, дотоод сүлжээ байгуулах болон камер суурилуулах ажлын УБЕГ/202016 дугаартай тендэрийн үнийн санал авах урилгыг 2020 оны 01 сарын 31-ний өдөр ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу харьцуулалтын аргаар тендер шалгаруулалт аргаар зарлаж, тус бүр гурван компанид зар хүргүүлж, 2020 оны 02 сарын 07-ны өдрийн 12 цаг 00 минут хүртэл тендер хүлээн авсан. Тендэрийн нээлтийг

2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 12 цаг 50 минутад нээхэд архивын тавиур нийлүүлэх УБЕГ/202017 тендэрт “Өвөрбогд” ХХК 22 400 000 төгрөг, “Бөжэ” ХХК 22 000 000 төгрөг, “Цэдэв” ХХК 21 120 000 төгрөгөөр нийлүүлэх үнийн санал, шилэн кабель, дотоод сүлжээ байгуулах болон камер суурилуулах ажлын тендэрт “Ас Сейф Лайн” ХХК 25 245 000 төгрөг, “Ай Ти Ти Эс” ХХК 21 131 000 төгрөгийн ирүүлсэн материалыг эрх бүхий эсэх, гэрээ хэрэгжүүлэх чадвар, тендерийн иж бүрдэл, шаардлагад нийцэж буй эсэх, үндсэн шаардлагыг хангасан эсэхийг хянан үзэж захиалагчид дүгнэлтийг хүргүүлсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 28.3 дахь хэсэгт заасан шаардлагад нийцсэн тендер ирүүлсэн архивын тавиур нийлүүлэх УБЕГ/202017 тендерт “Өвөрбогд” ХХК шалгарсан тул төсөвт өртөгт багтаан 19 008 000 /арван есөн сая найман мянга/ төгрөгөөр гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг 2020 оны 02 сарын 10-ны өдрийн 3/1327 тоотой, Шилэн кабель, дотоод сүлжээ байгуулах болон камер суурилуулах ажлын УБЕГ/202016 дугаартай тендерт “Ас Сейф Лайн” ХХК-д 21 131 000 төгрөгөөр шалгарсан гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг 2020 оны 02 сарын 10-ны өдрийн 3/1325 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.

Гэрээнүүдийг дүгнэх актыг тус тус үйлдэн ажилласан.

1.3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэгдээгүй болон дутуу биелсэн ажлын шалтгаан, цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааны талаар:

Төлөвлөгөөний дагуу биелэгдээгүй худалдан авалт байхгүй.

1.4. Тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн хүчинтэй байх хугацаанд хийсэн талаар:

2020 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу тендер шалгаруулалтын үнэлгээг хуулийн хүрээнд тендер хүчинтэй байх хугацаанд зохион байгуулсан.

1.5. Худалдан авах ажиллагааны явцад гарсан зөрчил, түүнийг хэрхэн засаж залруулсан талаар:

2020 оны байдлаар тус газраас зарлагдсан худалдан авах ажиллагаатай холбоотой гарсан зөрчил байхгүй.

1.6. Худалдан авах ажиллагааны талаар гарсан гомдол, түүнийг шийдвэрлэсэн талаар:

1.6.1 Бичиг хэргийн материал нийлүүлэх тендерийн бичгийн цаас багцад Ти Ай Эм ХХК-нь Сангийн яаманд гомдол гаргасан байна. Сангийн яамнаас 2020 оны 03 сарын 24-ны өдрийн 6-1/1781 тоот албан тоотой гомдол ирүүлсэн талаар нотлох баримт хангалтгүй шалтгаанаар тус байгууллагад гаргасан гомдлыг буцаасан тухай албан тоотыг ирүүлсэн тул үнэлгээний хорооны шийдвэрийг хүчин төгөлдөр гэж үзэн гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг хүргүүлсэн.

Бусад худалдан авах ажиллагаатай холбоотой гарсан санал, гомдол байхгүй.

1.7. Чанар стандартын шаардлага хангасан дотоодын бараа худалдан авсан мөнгөн дүн, нийлүүлэгчийн нэр, гэрээний хэрэгжилтийн талаар:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10¹ дүгээр заалт “Дотоодын үйлдвэрээс бараа худалдан авах”, Засгийн газрын 2015 оны “Дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны жагсаалт” батлах тухай 336 дугаар тогтоолыг үндэслэн дотоодын үйлдвэрлэлийг дэмжин дараах худалдан авалтыг хийсэн. Үүнд:

1.7.1 Үндэсний үнэт цаас ХХК –тай “Гэрчилгээ, үнэмлэх, лавлагаа, маягт нийлүүлэх” тендерээр 272,0 сая төгрөг, Хөх монгол принт ХХК-тай “Хавтас, дэвтэр, мэдүүлэг нийлүүлэх” тендерээр 218,7 сая төгрөгийн гэрээ тус тус байгуулж ажиллаж байна. Гэрээний хэрэгжилт 50 хувь;

1.7.2 Титан би ХХК-тай “Гадаад паспортын захиалгын хуудас” нийлүүлэх шууд гэрээгээр 19,0 сая төгрөгийн захиалгын хуудас хүлээн авах гэрээ хийгдсэн. Гэрээний хэрэгжилт 20 хувь;

1.7.3 Архивын ерөнхий газартай “Албан бичгийн хэвлэмэл хуудас” нийлүүлэх гэрээний дагуу 10,8 сая төгрөгийн хэвлэмэл хуудас тус тус хүлээн авсан. Гэрээний хэрэгжилт 100 хувь;

1.7.4 Шатахуун нийлүүлэх тендерт шалгарсан Петростар ХХК-тай шатахуун нийлүүлэх 23,0 сая төгрөгийн гэрээний дагуу шатахуун талоньг сар бүр хуваарийн дагуу хүлээж авсан. Гэрээний хэрэгжилт 50 хувь.

1.7.5 Зөв өнгө ХХК-тай принтерийн хор нийлүүлэх гэрээний дагуу 49,9 сая төгрөгийн бараа материал хүлээн авч байна. Гэрээний хэрэгжилт 40 хувь.

ХОЁР. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНД ЦАХИМ СИСТЕМ АШИГЛАСАН ТАЛААР

2.1. Худалдан авах ажиллагааны цахим системээр зарласан тендер шалгаруулалтын тоо, хувь болон системийн талаар:

Худалдан авах ажиллагааны цахим системээр урсгал зардлаас нээлттэй тендер шалгаруулалт 4, харьцуулалтын аргаар тендер шалгаруулалт 1 тус тус зарласан, үр дүнг тайлагнасан болно.

2.2. Ерөнхий гэрээ байгуулах журмын дагуу цахим дэлгүүрийн ашиглалт болон тухайн жилд худалдан авсан бараа, үйлчилгээний тоо, мөнгөн дүн, гэрээний хэрэгжилтийн талаар:

Ерөнхий гэрээ байгуулах журмын дагуу цахим дэлгүүрийн худалдан авалт хийгээгүй болно.

2.3. Мэргэжлийн байгууллага ерөнхий гэрээний зохион байгуулсан тендер, шалгарсан аж ахуй нэгжийн тоо, шалгараагүй оролцогчийн үндэслэл болон холбогдох мэдээлэл, худалдан авалт хийсэн бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хэрэгжилтийн талаар:

Худалдан авалт байхгүй.

ГУРАВ. ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

3.1 Ерөнхий газар:

Нээлттэй тендер шалгаруулалт

- Улсын бүртгэлийн ерөнхий газрын албан хэрэгцээнд шаардагдах улсыг мэдээллийн маягт нийлүүлэхээр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах УБЕГ-ын даргын 2020 оны А/61 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний үнэлгээний хорооны ажиллагаа болон үр дүн:

- Батлагдсан төлөвлөгөөний дагуу 2020 оны 1 сарын 13-ны өдөр уг тендерийг зохион байгуулахаар tender.gov.mn цахим мэдээллийн санд тендерийн бичиг баримт болон урилгыг байршуулан ажилласан.
- Улсын мэдээллийн маягт хэвлэх худалдан авах ажиллагааг 2 багц болгон /Багц-1 нь гэрчилгээ, үнэмлэх, лавлагаа, маягт, багц-2 нь хавтас, дэвтэр, мэдүүлэг/ тендерийн нээлтийг 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдөр цахимаар зохион байгуулж ажилласан.
- **Багц-1 буюу Гэрчилгээ, үнэмлэх, лавлагаа, маягт нийлүүлэх тендерт** “Соёмбо принтинг” ХХК-ийн үнийн санал 253 500 000 төгрөг, “Үндэсний үнэт цаас” ХХК-ийн үнийн санал 272 030 000 төгрөг, **Багц-2 буюу Хавтас, дэвтэр, мэдүүлэг нийлүүлэх тендерт** “Грийт пийк” ХХК-ийн үнийн санал 345 092 000 төгрөг, “Хөх монгол принтинг” ХХК-ийн үнийн санал 218 660 000 төгрөг, “Соёмбо принтинг” ХХК-ийн үнийн санал 221 714 000 төгрөг, “Адмон принт” ХХК-ийн үнийн санал 335 346 000 төгрөгөөр оролцохоор тендерийн материалаа ирүүлсэн.
- Үнэлгээний хороо хуралдаж Багц-1д “Соёмбо принтинг” ХХК-иас ирүүлсэн тендер нь тендерийн баримт бичгийн бүрдэл хэсэг, техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4-т заасныг үндэслэн тухайн тендерийн материал хянан үзэх шатнаас хасагдаж, үлдсэн **“Үндэсний үнэт цаас” ХХК** -иас тодруулга авахаар албан бичиг хүргүүлж, тодруулгын хариу ирэхээр дүгнэлтээ гарган захиалагчид танилцуулахаар шийдвэрлэсэн. Багц-2-д Грийт пийк” ХХК-ийн хувьд тендерийн баримт бичгийн бүрдэл хэсэг, техникийн тодорхойлолтын шаардлагыг хангаагүй, Соёмбо принтинг” ХХК, “Адмон принт” ХХК-ийн хувьд тендерийн баримт бичгийн бүрдэл хэсэг дутуу, шаардлага хангаагүй тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4-т заасныг үндэслэн хянан үзэх шатнаас хасагдаж, тендерийн баримт бичгийн бүрдэл хэсэг, техникийн тодорхойлолтын шаардлага хангасан, хамгийн сайн үнэлэгдсэн тендерээр **“Хөх монгол принтинг”** ХХК-ийн ирүүлсэн тендер шалгарч байгаа тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29-д заасны дагуу гэрээ байгуулах саналыг захиалагчид танилцуулахаар шийдвэрлэсэн.
- Багц-1 буюу Гэрчилгээ, үнэмлэх, лавлагаа, маягтын багцад шалгарсан **Үндэсний үнэт цаас** ХХК нд 2020 оны 3 сарын 4-ны өдрийн 1/2069 тоотоор **272 030 000 төгрөгөөр**, Багц-2 буюу Хавтас, дэвтэр, мэдүүлгийн багцад шалгарсан **Хөх монгол принтинг ХХК**-нд 2020 оны 3 сарын 4-ны өдрийн 1/2073 тоотоор **218 660 000 төгрөгөөр гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл тус тус хүргүүлж, 2020 оны 3 сарын 13-ны өдөр дээрх 2 байгууллагатай гэрээ байгуулан ажилласан.**

- Улсын бүртгэлийн ерөнхий газрын албан хэрэгцээнд шаардагдах шатахуун нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах УБЕГ-ын даргын 2020 оны А/62 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны ажиллагаа болон үр дүн:

- Батлагдсан төлөвлөгөөний дагуу 2020 оны 1 сарын 13-ны өдөр уг тендерийг зохион байгуулахаар tender.gov.mn цахим мэдээллийн санд тендерийн бичиг баримт болон урилгыг байршуулан ажилласан.
- Шатахуун нийлүүлэх тендерт 3 байгууллага оролцохоор материалаа материалаа ирүүлснийг үнэлгээний хороо хянан үзэж ТБОНӨХБАҮХАТХуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3 дахь хэсэгт заасан тендерийн баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлага буюу тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд дурьдсан гэрээгээр гүйцэтгэсэн 3-аас доошгүй байгууллагын гэрээ дүгнэсэн актыг “Магнайтрейд” ХХК-нь дутуу ирүүлсэн, “Содмонгол” ХК нь огт ирүүлээгүй тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсэгт заасныг баримтлан уг тендерээс татгалзаж, “Петростар” ХХК-иас ирүүлсэн тендер нь тендерийн баримт бичгийн шаардлага хангаж байгаа болон ирүүлсэн үнийн санал нь захиалагчийн тооцсон төсөвт өртөгт багтаж байгаа тул “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн тул “Петростар” ХХК-д гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг 2020 оны 3 сарын 5-ны өдрийн 1/2172 тоотойр **22 950 200 төгрөгөөр** гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг хүргүүлж, 2020 оны 3 сарын 13-ны өдөр гэрээ байгуулсан.

-Улсын бүртгэлийн ерөнхий газрын албан хэрэгцээнд шаардлагатай багаж, техник хэрэгсэл нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах УБЕГ-ын даргын 2020 оны А/67 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны ажиллагаа болон үр дүн:

- Батлагдсан төлөвлөгөөний дагуу 2020 оны 2 сарын 03-ны өдөр иргэний үнэмлэхийн хэвлэх үйлдвэрт ээлжит засвар үйлчилгээг хийж, холбогдох сэлбэг хэрэгслийг солиход хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулалт зохион байгуулж 2020 оны 2 сарын 3-ны өдөр урилгыг 3 байгууллагад хүргүүлж, 2020 оны 2 сарын 13-ны өдөр нээж ажлын хэсэг дүгнэлтээ гарган захилагчид танилцуулсан. 2020 оны 2 сарын 27-ны өдрийн 1/1881 тоот албан бичгээр **Смарткарт ХХК** -д гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл хүргүүлснээр 2020 оны 3 сарын 11-ны өдөр **118 917 992 төгрөгөөр** нийлүүлж, суурилуулахаар гэрээ байгуулан, гэрээний дагуу ажлыг хүлээн авч акт үйлдсэн.

- Улсын бүртгэлийн ерөнхий газрын албан хэрэгцээнд шаардлагдах бичиг хэргийн материал нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах УБЕГ-ын даргын 2020 оны А/68 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны ажиллагаа болон үр дүн:

- Батлагдсан төлөвлөгөөний дагуу 2020 оны 1 сарын 13-ны өдөр уг тендерийг зохион байгуулахаар tender.gov.mn цахим мэдээллийн санд тендерийн бичиг баримт болон урилгыг байршуулан ажилласан.
- Батлагдсан төлөвлөгөөний дагуу 2020 оны 1 сарын 13-ны өдөр уг тендерийг зохион байгуулахаар tender.gov.mn цахим мэдээллийн санд тендерийн бичиг баримт болон урилгыг байршуулан ажилласан.

- Бичиг хэргийн материалын худалдан авах ажиллагааг 2 багц болгон /Багц-1 нь бичгийн цаас, багц-2 нь принтерийн хор/ тендерийн нээлтийг 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдөр цахимаар зохион байгуулж ажилласан.
- **Багц-1 буюу бичгийн цаас нийлүүлэх** багцад нийт 4 байгууллага оролцохоор материалаа цахимаар илгээж, үнэлгээний хороо шаардлагад нийцсэн 1 ч тендер байхгүй шалтгаанаар тендерийг дахин 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдөр tender.gov.mn цахим мэдээллийн санд байршуулж, 2020 оны 4 сарын 18-ны өдөр нээлтийг хийхэд 2 байгууллага оролцохоор материалаа ирүүлсэн. Үнэлгээний хороо хуралдаж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх хэсэгт зааснаар шаардлагад нийцээгүй тул мөн хуулийн 30.4.3 дахь заалтыг баримтлан **Таван богд менежмент ХХК-тай 74 100 000 төгрөгөөр** шууд гэрээг байгуулахаар 2020 оны 5 сарын 27-ны өдөр албан тоотыг хүргүүлсэн.
- **Багц-2 буюу принтерийн хор нийлүүлэх** багцад 7 байгууллага оролцохоор материалаа цахимаар илгээж, үнэлгээний хороо тендерийн хуулийн дагуу хянан үзэж шаардлагад нийцсэн гэж захиалагчид танилцуулсан боловч Сангийн яаманд Ти Ай оролцогч Эм ХХК нь гомдол гаргаж, гомдол гаргасан материал үндэслэлгүй шалтгаанаар Сангийн яамны 2020 оны 03 сарын 24-ны өдрийн 6-1/1780 тоот албан бичгээр гомдлыг буцаасан тухай хариу ирүүлсэн тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан, 28 дугаар зүйлийн 28.3, 28.7.4-т заасны дагуу хамгийн сайн үнэлэгдсэн тендерээр шалгарсан тул **Зөв өнгө ХХК-нд** 2020 оны 3 сарын 24-ны өдрийн 1/2117 тоотор **49 898 880 төгрөгөөр** гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл хүргүүлж, 2020 оны 3 сарын 31-ны өдөр гэрээг байгуулан ажилласан.

3.2 Орон нутаг:

1	Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчил гээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал		Төсөвт өртөг (мян.төг)	ХАА-нд мөрдсөн журам	Тайлбар, тодруулга
-	Нийт дүн		44,730.5	-	-
1	Принтер-7 ширхэг	M102a, MFJ M130A, HP laserJetPro	3,278.0	ШХА	Хэнтий Засаг даргын байгуулсан 2020.03.10-ны өдрийн ОНТ-2020/02 тоот гэрээний дагуу
2	Скайнэр-1 ширхэг	Epson DS-530 Color	1,518.0	ШХА	
3	Компьютер-3 ширхэг	Dell-2216H, Processor Aser XC885-008	5,134.5	ШХА	
4	Автомашин	Hyundai Starex	34,800.0	НТШ	Дорноговь аймгийн Засаг даргын 2020.03.03-ны өдрийн А/236 тоот захирамжаар нийлүүлэгч Отто мир ХХК-нд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл хүргүүлсэн

ДӨРӨВ. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ДҮГНЭЛТ

4.1.Төлөвлөгөөний хугацаа биелэгдээгүй шалтгаан

Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар баталсан Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд заасан хугацаа дараах үндэслэлээр хойшлогдсон. Үүнд:

- Бичиг хэргийн материалын багц-1 буюу бичгийн цаас нийлүүлэх тендерт шаардлагад нийцсэн тендерт оролцогч гараагүй тул хүчингүй болгож, дахин зарласан тул төлөвлөгөөний гэрээ байгуулах хугацаанд өөрчлөлт орсон.

4.2.Төсвийн захирагч тухайн жилийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн үр дүнгийн талаарх өөрийн үнэлгээ, дүгнэлт

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь буюу худалдан авах ажиллагаа хууль, тогтоомж, дүрэм, журмын дагуу зохион байгуулагдаж байна.

4.3.Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг цаашид улам үр дүнтэй болгох санал, зөвлөмж

Бичиг хэргийн цахим дэлгүүрийн үйл ажиллагааг хэрэгжүүлбэл төрийн байгууллагуудад үр ашигтай, цаг, зардал хэмнэсэн ажил болох тул энэ ажлыг зохион байгуулах талаар холбогдох газарт уламжилж өгөхийг санал болгож байна.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР